

**БОЛОВСРОЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар. А/С, А/З

Улаанбаатар хот

Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ,
хэрэгжүүлэх төлөвлөгөө /2025-2028/ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 албан даалгаврын 1.12, 24.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ (2024-2028)-г нэгдүгээр, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, аймаг, нийслэлийн Боловсролын болон Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, баяжуулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Боловсролын яамны Цахим боловсролын газар /Т.Бат-Эрдэнэ/, Эрүүл мэндийн яамны Стратеги, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтэс /Э.Мягмар-Өлзий/-т тус тус үүрэг болгосугай.

4. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Б.Батцэцэг/, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газар /Э.Мөнхсүх/-т тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Боловсролын яамны Салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/ Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар /Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.



Боловсролын сайд, Эрүүл мэндийн
сайдын 2025 оны 02 дугаар сарын
06 өдрийн А/СЗ. /.../ дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр
хавсралт

“ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ” АРГА ХЭМЖЭЭ (2025-2028)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй” гэж, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд төрийн захиргааны төв байгууллага нь “Хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Сургуулийн эрүүл мэндийг дэмжих дэлхийн санаачилга”-ыг 1995 онд дэвшүүлж, сургуулийн сургалтын үйл ажиллагаа, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг бэхжүүлснээр хүүхэд, өсвөр үеийнхэн, тэдний гэр бүл, сургуулийн ажилтны эрүүл мэндийг сайжруулахыг зорьсон. Эрүүл мэндийг дэмжигч сургууль нь эрүүл амьдрах, суралцах, ажиллах хүчин чадлыг тогтмол бэхжүүлэхийг онцолж, бие бялдар, нийгэм-сэтгэц, сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсролын үр дүнг сайжруулахад сургуулийн өөрийн боломжит нөөцөөр дамжуулан суралцагч, багш ажилтны эрүүл мэнд, боловсролыг дэмжих явдал гэж үзжээ. Энэхүү санаачилгыг өргөжүүлэхээр 2018 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО) хамтран “Сургууль бүр эрүүл мэндийг дэмжигч сургууль болох” санаачилгыг дэвшүүлж, эрүүл мэндийг дэмжигч сургуулийн стандарт, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, стандартад суурилсан аргачлалаар улс орнууд хэрэгжүүлэхийг чухалчилсан.

Энэхүү санаачилгыг ЮНЕСКО дэмжин “Эрүүл мэнд, сайн сайхан байдлын боловсролын стратеги”-ээ шинэчлэн, “Сургуулийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх цогц аргачлалыг нэвтрүүлэхэд боловсролын салбар болон бусад оролцогч талуудыг дэмжсэнээр бүх суралцагчийн эрүүл мэнд, сургалтын үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах” зорилгыг дэвшүүлсэн. Зорилгын хүрээнд гурван зорилтыг дэвшүүлсэн бөгөөд үүнд: 1) суралцагчийн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжсэн сургуулийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх; 2) Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), амьдрах ур чадвар, гэр бүл, хүний эрхийг багтаасан чанартай, жендэрийн тэгш байдлыг хангасан, бэлгийн цогц боловсролтой суралцагчийг бий болгох; 3) бүх хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолт зэргээс ангид аюулгүй, оролцоот сурах орчныг бүрдүүлэх хэмээн тусгасан.

Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ нь суралцагчдад эрүүл, аюулгүй сурч боловсрох орчныг бүрдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж, эрүүл амьдрах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлснээр тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилготой бөгөөд эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл амьдрах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэн тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд оршино.

2.2.Арга хэмжээ нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

2.2.1.Эрүүл, аюулгүй сургуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2.Суралцагч, багш, ажилтны эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;

2.2.3.Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэх;

2.2.4.Сургуульд эрүүл, аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх;

2.2.5.Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх;

2.2.6.Оролцогч талуудын тэгш оролцоо, түншлэл, үр дүнтэй хамтын ажиллагааг эхлүүлэх.

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1. Арга хэмжээний зорилтыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хүний эрхийг хүндэтгэсэн, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхийг тэгш хангасан байх;

3.1.2.хүүхэд бүрт тэгш боломж олгосон, нэг ч хүүхдийг орхигдуулахгүй байх;

3.1.3.хувь хүний хэрэгцээ, ялгаатай байдалд тохирсон, уян хатан, соёлын болон жендэрийн мэдрэмжтэй байх;

3.1.4.хувийн мэдээллийг хамгаалсан, хүмүүнлэг байх;

3.1.5.гэр бүл, иргэн, төр, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, хариуцлагад суурилсан байх;

3.1.6.хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүртээмжтэй, тогтвортой байх¹.

Дөрөв. Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт

4.1.Арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2.Арга хэмжээний хэрэгжилтийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яам үндэсний түвшинд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3.Арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг 4.2-т заасан төрийн захиргааны төв байгууллагын манлайлал дор холбогдох яамд, агентлаг мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

4.4.Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд ерөнхий боловсролын сургуульд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;
- 5.1.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.


Зургаа. Арга хэмжээний шалгуур үзүүлэлт

6.1 “Эрүүл, аюулгүй сургууль”-ийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтүүдийг жил бүр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Мэдээллийн үзүүлэлтүүд		
			он	түвшин	2025 он	2026 он	2027 он	2028 он	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга	Мэдээлэл цуглуулах давтамж
1	Эрүүл, аюулгүй сургуульд зарцуулсан мөнгөн дүн	төгрөгөөр	2024	60.3 сая	Өмнөх оноос 10% нэмэгдүүлэх	Өмнөх оноос 10% нэмэгдүүлэх	Өмнөх оноос 10% нэмэгдүүлэх	Өмнөх оноос 10% нэмэгдүүлэх	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
2	Хүүхдийн төлөө орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд "Эрүүл, аюулгүй сургууль" талаар зохицуулалт тусгасан аймаг, дүүрэг	хувь	-	-	50	70	90	100	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
3	Эрүүл мэндийн зөвлөл байгуулсан сургууль	хувь	-	-	50	70	90	100	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
4	Эмчээр хангагдсан сургууль	тоо	2024	537	565	593	621	651	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
	Сэтгэл зүйчээр хангагдсан сургууль	хувь	2024	42	55	65	80	90	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
	Хоол зүйчээр хангагдсан сургууль	хувь	2024	20	30	40	50	60	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
5	Хүүхдийн санал, гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг бүрдсэн сургууль	хувь	2024	85	88	93	97	100	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-тай сургуулийн хувь	хувь	2023	30	35	43	50	60	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
7	Багш, ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт	хувь	-	-	75	80	90	100	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
8	Суралцагчийн амны хөндий-шүд цоорлын эрүүлжилт	хувь	2023	32.6	45.0	60.0	70.0	80.0	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа

9	Халдварт өвчин, хоолны хордлогын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөтэй сургууль	хувь	2023	5.0	50	70	90	100	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
10	Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн сургуулийн тоо, өвчний төрлөөр	тоо	2023	1.5	0.0	0.0	0.0	0.0	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
11	Сургуулийн орчинд хоолны хордлогын дэгдэлт бүртгэгдсэн сургуулийн тоо	тоо	-	-	0.0	0.0	0.0	0.0	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
12	Сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн сургуулийн тоо (2 болон түүнээс дээш)	тоо	2024	30	30	25	20	15	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
13	Сургуулийн орчинд бүртгэгдсэн осол гэмтлийн тохиолдлын тоо	тоо	2023	10123	9500	9000	8500	8000	ЭМЯ	Эрүүл мэндийн үзүүлэлт	Жилд нэг удаа
14	Сургуулийн орчинд бүртгэгдсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлын тоо	тоо	-	-	Өмнөх оноос 10% бууруулах	Өмнөх оноос 10% бууруулах	Өмнөх оноос 10% бууруулах	Өмнөх оноос 10% бууруулах	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
15	Ундны цэвэр ус уух боломж бүрдүүлсэн сургууль	хувь	2024	40	50	60	70	80	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
16	Шүд угаах цэгтэй сургууль	хувь	2024	17	30	45	60	75	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа
17	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай сургууль	хувь	2024	80	85	90	95	100	БЯ	Боловсролын салбарын статистик	Жилд нэг удаа

---000---



Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын
2025 оны дугаар сарын 06 өдрийн
А/024/11 дугаар тушаалаар хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025-2028 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт			Хэрэгжүүлэх байгууллага				
					2025 он		Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хариуцагч	Хамтрагч	Оролцогч	
					Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт						Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Зорилт 1. Эрүүл, аюулгүй сургуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох												
		2025-2028	Сургууль бүрд эмч ажиллах орон тооны норматив- нормативт нийцүүлэн эмчтэй болгох	Боловсролын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны норматив	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад ажилтны орон тооны жишиг нормативыг шинэчлэн баталсан байна.	-	-		БЯ	ЭМЯ, СЯ	ОУБ, ИНБ	
		2025	Сургуулийн эмчийн албан тушаалын тодорхойлолт	Эрүүл мэнд, Боловсролын сайдын 2018 оны А/494, А/761 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт	Сургуулийн эмчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна.	-	-		БЯ, ЭМЯ	ГБХНХЯ	ОУБ, ИНБ	
		2025-2026	Багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн багц	Багшийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал (Застийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол)	Багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн төрөл, сонголтыг нэмэгдүүлэх шийдвэр гарсан байна.	Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн дэх "Эрүүл мэндийн үйлчилгээний зардал"-ын хувь хэмжээ нэмэгдсэн байна.	-		БЯ, ЭМЯ, СЯ	-	ОУБ, ИНБ	
		2025-2026	Сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд тусгагдсан эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны зардал, хувь хэмжээ	ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт	Сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд тусгах эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны зардал тооцоолол хийгдсэн байна.	Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны зардал тусгах, арга хэмжээ авсан байна.	-		БЯ, СЯ, ЭМЯ	БСҮХ	ОУБ, ИНБ	
1.1 Сургуулийн орчныг эрүүл, аюулгүй, ээлтэй болгохтой холбоотой хэм хэмжээний актыг хөгжлийн шаардлагад нийцүүлэн сайжруулна.		2025	Нэмэлт, өөрчлөлт орсон захиргааны акт	"Норматив батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/166 А/559 А/222 дугаар тушаал	Хүүхдийн хоолноос авбал зохих эрдэс бодис амин дэм, хүнсний эсэлгийн хэмжээтэй холбоотой зохицуулалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/166 А/559 А/222 дугаар хамтарсан тушаалд шинээр тусгаж баталсан байна.	-	-		БЯ	ЭМЯ ХХААХҮЯ	ОУБ, ИНБ	
		2025-2026	Суралцагчийн эрүүл мэндийн цахим карт	-	Суралцагчийн эрүүл мэндийн картан төсөл боловсруулж, цахим систем хөгжүүлтийг эхлүүлсэн байна.	Суралцагчийн эрүүл мэндийн карт, цахим системд шилжүүлсэн байна.	-		ЭМЯ БЯ	-	ОУБ, ИНБ	

2025	Хүүхдийн төлөө салбар зөвлөлийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт	-	Хүүхдийн төлөө орон нутгийн салбар зөвлөлийн дүрэмд "Эрүүл, аюулгүй сургууль" талаар зохицуулалт тусгасан байна.	-	-	БЯ, ЭМЯ, ЗДТГ	-	-
2025	Эрүүл мэндийн зөвлөл ажиллах зохицуулалттай сургуулийн тоо	-	"Эрүүл мэндийн зөвлөл ажиллах" зохицуулалтыг ерөнхий боловсролын сургуулийн дүрэмд тусгасан байна.	-	-	БЯ	ЭМЯ, ЕБС, МТСБ	-
2025	Суралцагч, багш, ажилтан биеийн тамирын заалыг төлбөргүйгээр ашиглуулах шийдвэр	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/333	Суралцагч, багш, ажилтан хичээлийн бүс цагаар сургуулийн биеийн тамирын заалыг төлбөргүйгээр чөлөөтэй ашиглах боломжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	БЯ	-	-
2025-2028	Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого		Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг боловсруулж, "Эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, үйлчилгээг суралцагчдад үзүүлэх аруулга бүхий заалтыг тусгасан байна.	Сургууль бүр хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	-	БЯ	-	-
2025-2026	Эрүүл, аюулгүй сургуулийг үнэлэх үнэлгээний нэгдсэн аргачлал		Эрүүл, аюулгүй сургуулийг үнэлэх үнэлгээний нэгдсэн аргачлал боловсруулагдсан байна.	Эрүүл, аюулгүй сургуулийн үнэлгээ хийх удирдамж, гарын авлага боловсруулж, түгээсэн байна.	-	ЭМЯ	БЯ	ИНБ
2025-2028	"Эрүүл, аюулгүй сургууль"-ийн 4 жилийн төлөвлөгөө боловсруулсан аймаг, дүүргийн тоо	-	Аймаг, нийслэлдүүрэг бүр харьяа сургуулиудын орчны аюулгүй байдлын үнэлгээ, эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд үндэслэн эрүүл, аюулгүй сургуулийн төлөвлөгөө батлуулсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилт 85% дээш	Төлөвлөгөөний хэрэгжилт 85% дээш	ЗДТГ, БГ, ЭМГ	-	ОУБ, ИНБ
2025-2028	"Эрүүл, аюулгүй сургууль"-ийн 4 жилийн төлөвлөгөө боловсруулсан сургуулийн хувь	-	Сургууль бүр өөрийн орчны үнэлгээ, эрүүл мэндийн нотолгоонд суурилсан мэдээлэлд үндэслэн эрүүл, аюулгүй сургуулийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, захирлаар батлуулсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилт 85% дээш	Төлөвлөгөөний хэрэгжилт 85% дээш	ЕБС	БЕГ	ОУБ, ИНБ
Зорилт 2. Суралцагч, багш, ажилтны эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх								
2.1	Ерөнхий боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрөөр шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэсэн суралцагч тоо	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрөөр шинэчилсэн суралцагч буй суралцагчийн тоо 776.817	Эрүүл мэндийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа бага ангийн суралцагчийн тоо 381,000	Эрүүл мэндийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа бага, дунд ангийн суралцагчийн тоо 682,007	Эрүүл мэндийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа нийт 1-12 дугаар ангийн суралцагчийн тоо 870,489	БЯ	Холбогдох яамд	ОУБ, ИНБ
2.2	Сургууль бүр эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хичээллэж гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлд нийцүүлэн зорилтот арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хөтөлбөр, арга хэмжээний тоо	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох стратеги, Сэтгэцийн эрүүл мэнд-LIVE LIFE хөтөлбөр, эрүүл ахуй-PHAST, CHAST зэрэг хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Хөтөлбөр, арга хэмжээний тоо	Хөтөлбөр, арга хэмжээний тоо	БЕГ, ЗДТГ, БГ, ЭМГ, ЕБС, МТСБ	-	ОУБ, ИНБ
	Эрүүл мэндийг дэмжих клуб, дугуйлан ажиллуулсан сургуулийн хувь	20	Нийт сургуулийн 40 хувь	Нийт сургуулийн 60 хувь	Нийт сургуулийн 80 хувь	ЕБС, МТСБ	-	ИНБ, ААН

2.3	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээний чадвар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хүний нөөцийн чадаах бэхжүүлэх сургалт зохион байгуулна.	2025-2028	Сургалтад хамрагдсан багш, ажилтны хувь	-	Нийт багш, ажилтны 60 хувь	Нийт багш, ажилтны 80 хувь	Нийт багш, ажилтны 90 хувь	100 хувь	ЭМЯ, БЯ, БЕГ, ЕБС, МТСБ	ХХААХУЯ	ОУБ, ИНБ
3.1	Эрүүл, аюулгүй сургуулийн хяналт, тандалтын системийг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, суралцагч, багшийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний мэдээллийг системд бүртгэнэ.	2025-2028	Эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан хүүхдийн нас, эзлэх хувь	Нийслэлийн ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчийн 50 хувь	Эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд 6 настай хүүхдийн 80-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.	Эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд 6 настай хүүхдийн 80-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.	Эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд 6 настай хүүхдийн 80-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.	Эрүүл мэндийн эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд 6 настай хүүхдийн 80-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.	ЭМГ, ЕБС, МТСБ	БГ	ААН
3.2	Сургуулийн нийгэм-сэтгэл зүйн орчин (сургуулийн уур амьсгал, соёл, хандлага)-ы нөхцөл байдлыг тандан судалж, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	2025-2028	Судалгааны багцыг боловсруулах, хэрэгжүүлэх	-	Судалгааны багцыг боловсруулна.	50 хувь	70 хувь	90 хувь	БЕГ, БСҮХ, ЭМГ	ЕБС, МТСБ	-
3.3	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд тандалт, үнэлгээ хийнэ.	2025-2028	Үр дүнг системд бүртгэсэн сургуулийн хувь	-	20 хувь	40 хувь	80 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	БГ, ЭМГ	-
3.4	Эрүүл, аюулгүй сургуулийн орчны тандалт хийх, системд бүртгэх (Сургуулийн гадаад орчны агаар, хөрс болон бусад) тандалт хийх. Сургуулийн дотоод орчны барилга, агааржуулалт, температур, гэрэлтүүлэг, агаар, ширээ, сандлын эргономик, ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйд тандалт хийх, системд бүртгэх	2025-2028	Дотоод орчны тандалтыг тогтоосон хугацаанд хийж, системд бүртгэсэн сургуулийн хувь	-	20 хувь	40 хувь	80 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	БГ, ЭМГ	-
	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх		Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь (буурах)	-	Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Биеийн жингийн илүүдэл жинтэй суралцагчийн эзлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.		
			Өсөлтийн хоцрогдолтой суралцагчийн хувь (буурах)	-	10 хувь	15 хувь	20 хувь	25 хувь			
			Туранхай суралцагчийн эзлэх хувь (буурах)	-	10 хувь	15 хувь	20 хувь	25 хувь			

3.5 үзлэг, оношилтоогоор эрсдэлт хүчин зүйл илэрсэн, эсхүл хяналтад байдаг суралцагч, багш, ажилтныг эрүүл мэндийн байгууллагад илгээнэ.	2025-2028	Тамхи татдаг суралцагчийн зэлэх хувь (буурах)	-	Тамхи татдаг суралцагчийн зэлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Тамхи татдаг суралцагчийн зэлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	Тамхи татдаг суралцагчийн зэлэх хувь өмнөх оноос 10% буурсан байна.	ЭМГ, БГ	ЕБС, МТСБ	-
		Суралцагчийн амны хөндий-шүд цоорлын эрүүлжилтийн хувь	-	70 хувь	70 хувь	70 хувь			
		Багш, суралцагчийн өвчлөлийн түвшин /хувиар/	-	суралцагч (тоогоор)	суралцагч (тоогоор) өмнөх оноос 10% буурсан байна.	суралцагч (тоогоор) өмнөх оноос 10% буурсан байна.			
				багш (тоогоор)	багш (тоогоор) өмнөх оноос 10% буурсан байна.	багш (тоогоор) өмнөх оноос 10% буурсан байна.			
Зорилт 4. Сургуульд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх									
4.1 Сургуулийн биеийн тамирын заалыг хичээлийн бус цагаар суралцагч, багш ажилтан дасгал хөдөлгөөн хийх, үр дүнтэй ашиглах тэгш боломжийг бүрдүүлнэ.	2025-2028	Хичээлийн бус цагаар сургуулийн биеийн тамирын заал ашиглалтын хувь	-	60 хувь	80 хувь	90 хувь	ЕБС, МТСБ	-	-
4.2 Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг олон нийтэд мэдээлнэ.	2026-2028	Үр дүнгийн тайлан/эмхэтгэл	-	*Эрүүл, аюулгүй сургуулийн тайлан/эмхэтгэл боловсруулж, түгээсэн байна.	*Эрүүл, аюулгүй сургуулийн тайлан/эмхэтгэл боловсруулж, түгээсэн байна.	*Эрүүл, аюулгүй сургуулийн тайлан/эмхэтгэл боловсруулж, түгээсэн байна.	БЕГ, НЭМУТ	-	-
4.3 Сургуулийн гадаад орчны сайжруулна.	2025-2028	Гадаад орчны стандарт хангасан сургуулийн зэлэх хувь	30 хувь	40 хувь	60 хувь	70 хувь	ЕБС, МТСБ, ЗДТГ	БЕГ, ЭМГ	ИНБ, ААН
4.4 Дотоод орчны стандарт хангасан сургуулийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	Сургуулийн дотоод орчны стандарт шаардлага хангаж байгаа сургуулийн зэлэх хувь	60 хувь	70 хувь	80 хувь	90 хувь	ЕБС, МТСБ, ЗДТГ	ЭМЯ, СЯ	ОУБ, ИНБ
4.5 Ус, усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан сургуулийн тоог нэмэгдүүлнэ.	2025-2028	Агаар сэлгэлтийн систем нь барилгын хүчин чадалдаа бүрэн тохирсон сургуулийн зэлэх хувь	-	40 хувь	60 хувь	70 хувь	ЕБС, МТСБ	ЗДТГ, БГ, ЭМГ	ИНБ, ААН
		Ундны цэвэр ус уух боломж бүрдүүлсэн сургуулийн зэлэх хувь	40 хувь	50 хувь	70 хувь	80 хувь	ЕБС, МТСБ, ЗДТГ	ЭМЯ, СЯ	ОУБ, ИНБ
4.6 Эрүүл мэндийн хичээлийн кабинетийг шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэлдүүнээр хангана.	2025-2028	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай сургуулийн зэлэх хувь	80 хувь	85 хувь	95 хувь	100 хувь	ЕБС, МТСБ, ЗДТГ	ЭМЯ, СЯ	ОУБ, ИНБ
		Шүд угаах цэгтэй сургуулийн зэлэх хувь	17 хувь	30 хувь	45 хувь	75 хувь	ЕБС, МТСБ, ЗДТГ	ЭМЯ, СЯ	ОУБ, ИНБ
4.7 Сургуулийн хоолны газрын стандартын шаардлагыг үе шаттай хангана.	2025-2028	Эрүүл мэндийн хичээлийн сургалтын хэрэгсэлдүүнээр хангагдсан сургуулийн зэлэх хувь	5 хувь	15 хувь	30 хувь	45 хувь	БЕГ, ЕБС, МТСБ, ЗДТГ	ЭМГ	ОУБ, ААН
4.8 Суралцагчдыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хооллох үйлчилгээний хэрэгсэл (аяга, таваг, халбага, сэрээ)-ээр хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	Стандартын шаардлага хангасан хоолны газартай сургуулийн хувь	50 хувь	65 хувь	75 хувь	90 хувь	БЯ, ХХААХУЯ, БЕГ, ЕБС, МТСБ	СЯ, ЭМЯ, ЭМГ	-
		Хооллох үйлчилгээний хэрэгслээр хангагдсан сургуулийн хувь	10 хувь	20 хувь	50 хувь	100 хувь			
	2025-2028	Автомат аяга, таваг угаагч, ариутгагч төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн хувь	26.3 хувь	35 хувь	50 хувь	100 хувь	БЕГ, АНЗД, ЕБС, МТСБ	-	ОУБ, ИНБ, ААН

	Стандартын шаардлага хангасан эмчийн өрөөтэй сургуулийн хувь	25	30 хувь	50 хувь	70 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	БГ, ЭМГ, ЗДТГ	-
4.9	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлнэ.	2025-2028		15 хувь	30 хувь	60 хувь	ЕБС, МТСБ	БГ, ЭМГ, ЗДТГ	
4.10	Сургуулийн орчинд суралцагч, багш, ажилтан аямарч тайвшрах, алжаал тайлах таатай орчин бүрдүүлнэ.	2025-2028		30 хувь	50 хувь	70 хувь	БЕГ, ЕБС, МТСБ	ЗДТГ, ЭМГ	
	Орчин бүрдүүлсэн сургуулийн хувь	-	15 хувь	30 хувь	50 хувь	70 хувь	ЕБС, МТСБ	ЗДТГ, БЕГ, ЭМГ	ОУБ, ИНБ
Зорилт 5. Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх									
5.1	Ерөнхий боловсролын бүх сургуулийг эмтэй болгоно.	2026-2028	537	565 сургууль	593 сургууль	621 сургууль	651 сургууль	ЕБС, МТСБ	БГ, ЭМГ, ЗДТГ
5.2	Сэтгэл зүйчтэй сургуулийн тоог нэмэгдүүлнэ.	2026-2028	42 хувь	55 хувь	65 хувь	80 хувь	90 хувь	ЕБС, МТСБ	-
5.3	Ерөнхий боловсролын бүх сургуулийг хоол зүйчтэй болгоно.	2025-2028	20 хувь	30 хувь	40 хувь	50 хувь	60 хувь	БЯ, ЕБС, МТСБ	СЯ, ЭМЯ, ХХААХҮЯ
5.4	Сургуулийн орчинд суралцагч, багш, ажилтан эрүүл, шим тэжээллэг хоол, хүнсний үйлчилгээ үзүүлэх тэтгэл боломжийг бүрдүүлнэ.	2025-2028	-	40 хувь	70 хувь	100 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	ААН
5.5	Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнс, согтууруулах ундаа, 6.5 бүх төрлийн тамхины хэрэглээнд хяналт, үнэлгээ хийх, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	-
5.6	Сургуулийн орчинд өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг (дархлаажуулалт, идэвхтэй дасгал хөдөлгөөн, хорт зуршил) зохион байгуулах	2025-2028	27.9 хувь	50 хувь	55 хувь	60 хувь	65 хувь	ЭМЯ, ХӨСҮТ	ЗДТГ
	Зорилтот насны суралцагчдын хүний лапилома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын хамрагдах хувь		80.6 хувь	81 хувь	82 хувь	83 хувь	84 хувь	ЭМЯ, ХӨСҮТ	ЗДТГ
	Зорилтот насны суралцагчдын сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 1-р тунгийн хамрагдах хувь		71.9 хувь	72 хувь	73 хувь	74 хувь	75 хувь	ЭМЯ, ХӨСҮТ	ЗДТГ
	Зорилтот насны суралцагчдын сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 2-р тунгийн хамрагдах хувь		-	80 хувь	90 хувь	100 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	ЗДТГ
	Сургуулийн орчинд архи, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бүрэн хориглосон сургуулийн хувь		-	80 хувь	90 хувь	100 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	ЗДТГ
	Суралцагчид, багш, ажилтнуудын дунд идэвхтэй дасгал хөдөлгөөний зан үйлийг хэвшүүлэх зорилгоор сургуулийн орчинд өдөр тутам, тодорхой цагт нийтийн дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн сургуулийн хувь		-	80 хувь	90 хувь	100 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	ЗДТГ

	Сургуулийн орчинд халдварт өвчин, хоолны хордлогын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын сургуулийн хувь боловсруулах, хариу арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2025-2028	Хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөтэй сургуулийн хувь	5	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	ЭМГ, ХӨСҮТ	-
5.7			Сургалтад багш ажилтнаа хамруулсан сургуулийн хувь	-	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	ЭМГ, ЕБС, МТСБ	ХӨСҮТ	-
			Сургуулийн орчинд халдварт өвчин, хоолны хордлого бүртгэгдсэн тохиолдлын тоо	1.5	0	0	0	0	ЭМГ, ЕБС, МТСБ	ХӨСҮТ	-
			Жил бүрийн эрүүл мэндийн урьдчилан суралцагчдын хувь	-	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	БЕГ, БГ, ЭМГ, ЕБС, МТСБ	ЗДТГ	ААН
5.8	Багш, ажилтнууд, суралцагчдын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах	2025-2028	Насанд тохирсон эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан суралцагчдын хувь	-	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	85-аас дээш хувь	БЕГ, БГ, ЭМГ, ЕБС, МТСБ	ЗДТГ	ААН
			Жил бүрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан багш, ажилтнуудын хувь	-	75 хувь	80 хувь	90 хувь	100 хувь	БЕГ, БГ, ЭМГ, ЕБС, МТСБ	ЗДТГ	ААН
5.9	Эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийн нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх "Мэдээллийн сан" дэд системийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх	2025-2028	Дэд системд орсон эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээний төрөл • хүүхдийн нас, онцлогт тохирсон контентууд (ЭМ-ийн эрсдэлт хүчин зүйлс: эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, архи, тамхинаас татгалзах, стресс менежмент, нойр гм) • эрүүл мэндийн зарим өөрийн үнэлгээ • үр дүнд тохирсон зөвлөмж • шаардлагатай бол эмнэлэгт цаг авах, онлайн-аар эмчтэй холбогдох, утсан зөвлөгөө, холбогдсон нийгмийн сүлгууд	-				Мэдээллийн агуулга ба мэдээлэл түгээх хэлбэрт тогтмол шинэчлэл хийгдэж, мэдээлэл түгээх үйл явц сайжирсан байн	НЭМҮТ	ЭМГ, холбогдох үндэсний төв	БГ, ЕБС, МТСБ
Зорилт 6. Оролцогч талуудын тэтгэл оролцоо, түншлэл, үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх											
6.1	Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа (GSHS)-г 4 жилийн давамгайлт зохион байгуулна.	2028	Судалгааны тайлан	2024	-	-	-	Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа (GSHS) зохион байгуулж, тайлан тархаасан байна.	НЭМҮТ	БЕГ	ОУБ
6.2	Орон нутгийн хүүхдийн төлөө салбар зөвлөлийн хүний нөөцийг чадавхжуулж, хүүхдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлнэ.	2025-2028	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	100	100	100	100	БЯ-БЕГ, ЭМЯ-НЭМҮТ	ЕБС, МТСБ	ОУБ, ИНБ
		2025-2028	Зөвлөлөөс зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Үйл ажиллагааны тоо	Үйл ажиллагааны тоо	Үйл ажиллагааны тоо	Үйл ажиллагааны тоо	ЗДТГ, БГ, ЭМГ	ЕБС, МТСБ	ИНБ, ААН
6.3	Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	Зөвлөмж	-	Зөвлөмж боловсруулж хүргүүлсэн байна.	-	-	-	НЭМҮТ БЕГ	ОУБ, БГ, ЭМГ	-
		2025-2028	Сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан сургуулийн захирлын тоо	-	90 хувь	100 хувь	100 хувь	100 хувь	БЕГ, НЭМҮТ	ОУБ, ЕБС, МТСБ	-
			Эрүүл мэндийн зөвлөлтэй сургуулийн хувь	-	60 хувь	100 хувь	100 хувь	100 хувь			
6.4	Сургуулийн "Эрүүл мэндийн зөвлөл"-ийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2025-2028	Чадавхжуулах сургалтад хамрагдсан зөвлөлийн гишүүний тоо	-	100	101	102	103			ИНБ, ААН
			Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	50 хувь	80 хувь	100 хувь	100 хувь	ЕБС, МТСБ	БЕГ, ЭМГ	ИНБ, ААН

6.5	Боловсролын үйлчилгээний чанар, үр дүнгийн талаар санал, хүсэлт, гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй сувгийг сургуулийн орчинд бий болгож хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	Хүлээн авсан, шийдвэрлэсэн санал гомдлын тоо	-	Хүлээн авсан, шийдвэрлэсэн санал гомдлын тоо	Хүлээн авсан, шийдвэрлэсэн авсан санал гомдлын тоо	Хүлээн авсан, шийдвэрлэсэн санал гомдлын тоо	Хүлээн авсан, шийдвэрлэсэн санал гомдлын тоо	ЕБС, МТСБ, -		
			Шийдвэр гаргалтад хүүхдийн оролцоог хангасан сургуулийн хувь	-	75 хувь	80 хувь	90 хувь	100 хувь			